



## ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2018 оны 06 сарын 11 өдөр

Дугаар 9

Өндөрхаан

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Хурлыг 2018 оны 06 дугаар сарын сарын 11-ний өдрийн 11 цаг 00 минутад аймгийн Засаг даргын зөвлөлийн өрөөнд төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн Ч.Эрдэнэбаатар, Г.Болд, Г.Лхагвахатан Б.Сүнгээ, Л.Бат-Октябрь, Б.Баясайхан нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Болормаа нарын бүрэлдэхүүнтэй төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дарга Ж.Ганбаатар удирдан эхлүүлэв.

Хэлэлцсэн асуудал:

1. Өмнөдэлгэр сумын иргэн Л.Баярмаагийн өргөдлийн дүгнэлт танилцуулах
2. Л.Баярмаагийн үндэслэлгүй ажлаас чөлөөлсөн тухай өргөдөл
3. Нөөцийн сангаас нэр дэвшүүлэх тухай  
БСУГ-ын Байгалийн ухааны мэргэжилтэн - Д.Жаргалсайхан
4. Төрийн үйлчилгээний удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтын тухай

-Цэнхэрмандал сум

-Э.Навчаа

-Мөрөн сум

-Ц.Цэндбаяр

-Өмнөдэлгэр сум

-Б.Дарьхүү нарыг нэр дэвшүүлэх

5. Төрийн захиргааны удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтын тухай

тухай

-БОАЖГ -Б.Нямхатан

-Бор-Өндөр сумын Хурлын нарийн бичгийн дарга О.Сүхбаатар

-Баян-Адрага сумын ЗДТГ-ын дарга Б.Мөнхбат нарыг нэр дэвшүүлэх

-Б.Ундрах, Б.Баатарзолбоо Г.Ариунбаяр, Д.Энхчимэг, Э.Үүрцайх нарыг нөөцөд

бүртгэх

СОНССОН НЬ 1:

Дарга Ж.Ганбаатар: ээлжийн амралтын нөхөн олговор олгох тухай өргөдлийн дүгнэлтийг танилцуулах.

Гишүүн: Б.Баярсайхан: Өмнөдэлгэр сумын Засаг даргын тамгын газрын дарга Л.Баярмаагийн ээлжийн амралтын нөхөн олговор олгуулах талаар гомдол гаргасан байна. Үүн дээр өргөдөл гомдол шалгах комисс томилогдон 2 асуудал дээр дүгнэлт хийсэн байгаа. Дүгнэлтийг уншиж танилцуулав.

Дарга Ж.Ганбаатар: Дүгнэлттэй холбоотой асууж лавлах зүйл байна уу. Дэмжиж байгаа хүн байна уу.

С.Бат-Эрдэнэ: Төрийн албаны зөвлөл гэдэг чинь төрийн байгууллагын стандарт мөрдүүлэх ёстой байгууллага. Тэгэхэд нэг нь амар гэхэд амарч л байдаг нөгөө нь амар амар гээд амрааж л байдаг энэ чинь стандарт мөн юм уу тэр агуулгаараа наадах чинь буруу.

Ж.Гантулга. Төрийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйл дээр төрийн албан хаагчийн үүрэг гэж байгаа хууль тогтоомжийн биелүүлнэ гэж тэгэхээр нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайдын журмыг яагаад зөрчиж амарсан амралтын олговор олгогдоогүй шийдвэр гаргаагүй байхад амраад яагаад үүргээ биелүүлэхгүй байгаа юм Л.Баярмаа.

#### ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Гишүүдийн 80 хувийн саналаар Өмнөдэлгэр сумын иргэн Л.Баярмаагийн ээлжийн амралтын нөхөн олговор олгуулах тухай өргөдлийн маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцээд Л.Баярмаа нь Төрийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх хэсэгт заасан Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, Засаг даргын захирамж шийдвэргүйгээр ээлжийн амралт эдэлсэн байх тул нөхөн олговор олгох үндэслэлгүй гэж үзэх нь зүйтэй. Л.Баярмаад тогтоолыг албан бичгээр хүргүүлэхээр шийдвэрлэв.

#### СОНССОН НЬ 2:

Ж.Гантулга. Л.Баярмаагийн үндэслэлгүй ажлаас чөлөөлсөн тухай өргөдөл танилцуулан Нотлох баримт дахин гаргуулах шаардлагатай байгаа тул өргөдлийн шалгах хугацааг 2018 оны 06 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн 30 хүртэл хоногийн хугацаагаар сунгах саналтай байна.

#### ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Гишүүдийн 100 хувийн саналаар Л.Баярмаагийн өргөдлийг 30 хоногийн хугацаатай сунгах тогтоолыг албан бичгээр хүргүүлэхээр шийдвэрлэв.

#### СОНССОН НЬ 3:

Ч.Болормаа: Боловсрол соёл урлагийн газрын Байгалийн ухааны боловсрол хариуцсан мэргэжилтний орон тоон дээр нөөцөөс дэвшүүлж өгнө үү хэмээн Даваахүүгийн Жаргалсайханг санал болгосон. Д.Жаргалсайхан нь 2018 оны 4 дүгээр сарын 06-ны өдөр Дэс түшмэлийн ангилал дээр шалгалт өгөн Төрийн албаны зөвлөлийн тогтоолоор нөөцөд бүртгэгдсэн.

Ж.Ганбаатар: ажлын байрны тодорхойлолтын шаардлага хангаж байна уу

Ч.Болормаа: хангаж байгаа мэргэжил дагуу

#### ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Гишүүдийн 100 хувийн саналаар Д.Жаргалсайханг Боловсрол соёл урлагийн газрын Байгалийн ухааны боловсрол хариуцсан мэргэжилтний орон тоон дээр нөөцөөс нэр дэвшүүлэхээр шийдвэрлэв.

#### СОНССОН НЬ 4:

Ч.Болормаа: Төрийн үйлчилгээний удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтыг 6 дугаар сарын 06-ны өдөр бүртгэн 6 дугаар сарын 07-ны өдөр Л.Бат-Октябрь ахлагчтай салбар комисс томилогдон ажилласан. Төрийн үйлчилгээний Соёлын төвийн эрхлэгч нар дээр 6 суманд 7 иргэн бртгүүлсэн байгаа. Үүнээс 3 иргэн шалгалтад тэнцсэн. Цэнхэрмандал суманд Навчаа, Мөрөн суманд дээр Цэндбаяр, Өмнөдэлгэр суман дээр Дардхүү гэсэн 3 хүн тэнцэн тухайн албан тушаалд нь томилох байгаа.

Ж.Ганбаатар. Хууль журмын дагуу сонгон шалгаруулалтыг зарлан шалгагдаад гарсан хүмүүсийг томилох эрх бүхий этгээдэд уламжлах уу

Гишүүд: уламжлая.

#### ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Гишүүдийн 100 хувийн саналаар Цэнхэрмандал сумын Соёлын төвийн эрхлэгчээр Цэндбаярыг, Мөрөн сумын Соёлын төвийн эрхлэгчээр Навчаа, Өмнөдэлгэр сумын Соёлын төвийн эрхлэгчээр Дарьхүү нарыг томилуулахаар холбогдох баримт бичгийг албан бичгээр сумын Засаг дарга нарт нь хүргүүлэхээр шийдвэрлэв.

#### СОНССОН НЬ 5:

Ч.Болормаа: Төрийн захиргааны удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтыг төрийн үйлчилгээний удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалттай цуг зохион байгуулсан байгаа. Үүн дээр Байгаль орчин аялал жуулчлалын газрын Ойн албаны дарга, Бор-Өндөр сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга, Баян-Адрага сумын Засаг даргын Тамгын газрын даргын сул орон тоо гэсэн 3 орон тоо зарлагдсан. 12 иргэн бүртгүүлж шалгалт өгснөөс 8 иргэн тэнцсэн. Баян-Адрага сумын засаг даргын Тамгын газрын даргын орон тоон дээр 5 иргэн бүртгүүлснээр 3 иргэн тэнцсэн. Тухайн албан тушаалдаа хамгийн өндөр авсан 1 иргэнийг тухайн албан тушаалд нэр дэвшүүлэх, 2 иргэн нөөцөд бүртгэх,

Ж.Ганбаатар: Баян-Адрага сумын Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд нэр дэвшүүлж буй Б. Мөнхбатын дүгнэлтийг уншиж танилцуулав.

Ч.Болормаа: Байгаль орчин аялал жуулчлалын газрын Ойн албаны дарга дээр 5 иргэн бүртгүүлснээр 4 иргэн тэнцсэн байгаа. Хамгийн өндөр оноо авсан иргэн Нямхатан.

Ж.Ганбаатар: Байгаль орчин аялал жуулчлалын газрын Ойн албаны дарга албан тушаалд нэр дэвшүүлж буй Нямхатангын дүгнэлтийг уншиж танилцуулав.

Ч.Болормаа: Бор-Өндөр сумын дээр 2 иргэн өгснөөр 1 иргэн тэнцэж тухайн албан тушаалдаа нэр дэвшигдэн явж байгаа

Ж.Ганбаатар: Дээрх иргэдийг дэмжиж байна уу.

Гишүүд: дэмжиж байна.

#### ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Гишүүдийн 100 хувийн саналаар Баян-Адрага сумын Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд Б. Мөнхбатыг Байгаль орчин аялал жуулчлалын газрын Ойн албаны дарга албан тушаалд Нямхатанг, Бор-Өндөр сумын Иргэдийн Төлөөлгчдийн хурлын нарийн бичгийн даргын орон тоон дээр О.Сүхбаатар нарыг томилуулахаар холбогдох баримт бичгийг албан бичгээр эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхээр шийдвэрлэв.

Хурал: 12:30 минутад дуусав.

ХУРАЛ УДИРДСАН:

Ж.ГАНБААТАР

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

ХӨТӨЛСӨН:

Ч.БОЛОРМАА

